



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 09/07

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн  
С.Бямбацогт - Улсын Их Хурлын гишүүн  
Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн  
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн  
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Оюунбаатар - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ч.Өнөрбаяр - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх  
М.Батсуурь - Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүн  
Ц.Цогт - Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч  
А.Сарангэрэл - Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 20 дугаар шүүхийн шүүгч  
Ц.Ариунжаргал - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн  
Д.Сүнжид - Доктор, нийтийн эрх зүйн судлаач  
П.Одгэрэл - Доктор, нийтийн эрх зүйн судлаач  
Д.Ганзориг - Нийтийн эрх зүйн судлаач

А.Энхтуяа

-Ханнс-Зайделийн сангийн "Эрх зүйн боловсрол" академийн гүйцэтгэх захирал  
-Нээлттэй нийгэм форумын засаглалын хөтөлбөрийн менежер

Б.Хишигсайхан

Б.Баасандорж

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх  
-Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх

Ч.Ариунхур

-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх  
-Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөх

П.Сайнзориг

Ж.Бямбадулам

-Хууль зүйн байнгын хорооны референт  
-Төрийн байгуулалтын байнгын хорооны референт

Б.Хонгорзул

Б.Төрболд

3.Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны хамтарсан 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 05/05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

